



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 6 (435)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэрийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны хоёрдугаар сарын 14

№6 (435)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

77.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	130
78.	Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	132
79.	Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	132
80.	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	135
81.	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	138
82.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	138
83.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	138
84.	Төвийн эрчим хүчний дамжуулалтын сүлжээг шинэчлэн засварлах төслийн буцалтгүй тусламж, хүүгүй зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай	139
85.	Орон нутгийн зам сайжруулах төслийн зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай	139

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

86.	Мөнгөн тэмдэгтийн загвар, тодорхойлолт батлах тухай	Дугаар 06	139
87.	Үндэсний статистскийн газрын дарга, дэд даргад зэрэг дэв олгох журам батлах тухай	Дугаар 08	140
88.	Улсын Их Хурлын 2006 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 13	141
89.	Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай	Дугаар 16	142
90.	Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай	Дугаар 17	143
91.	Засгийн газрын гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай	Дугаар 18	143
92.	Ц. Элбэгдоржийг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 19	144
93.	Монгол Улсын Ерөнхий сайд асан Ц. Элбэгдоржийн хамгаалалт хангамжийн тухай	Дугаар 20	144
94.	Зарим хүмүүст тэтгэлэг олгох тухай	Дугаар 21	145
95.	Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 25	145

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

96.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 244	145
97.	"Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-ийг шагнах тухай	Дугаар 10	149
98.	Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 12	150
99.	Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 13	152

100. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Дугаар 14

152

## Доров, МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

101. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэх тухай

Дугаар 1/01

152

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

#### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3, 9, 14 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:**

"3.1.6."бизнес инкубацийн үйлчилгээ" гэж жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон эрхлэхийг хүссэн иргэнд үйлдвэрлэл, үйлчилгээний байр, орлоготой болоход нь мэдээллээр хангах, мэргэжлийн зөвлөлтөө өгөх зэргээр дэмжлэг үзүүлж, аж ахуй эрхлэх таатай орчин бүрдүүлэхийг."

**2/ 9 дүгээр зүйлийн 5, 6, 7 дахь хэсэг:**

"9.5 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр мэргэжлийн сургалтыг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдөнө.

9.6 Хувизараа хөдөлмөр эрхлэхийг хүссэн иргэн мэргэжлийн болон аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтад дэс дараатайгаар хамрагдаж болно.

9.7 Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан сангийн хөрөнгөөр мэргэжлийн сургалт зохион байгуулах, төсөгчдийг үнэлж, мэргэжлийн гэрчилгээ олгох үйл ажиллагааг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн дагуу зохион байгуулна."

**3/ 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:**

"14.1.7 аж ахуйн нэгж, байгууллага, иргэн гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсний төлөө төлөх ажлын байрны төлбөр;"

**2 дугаар зүйл.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт:**

"5.2.1 хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг судлах, хөдөлмөр эрхлээгүй иргэдийн судалгааг гаргах, тэднийг бүртгэх, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээллээр хангах;"

**2/ 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалт:**

"5.3.1 нөхөрлөл, хоршооны хэлбэрээр, түүнчлэн хувиараа болон өрхийн аж ахуй эрхлэх иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;"

**3/ 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

"7.1 Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн алба хөдөлмөрийн зах зээлийн судалгаа тогтмол явуулж, иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажил, мэргэжлээ сонгох, мэргэжлийн сургалтад хамрагдах нөхцөлийн талаар зөвлөлтөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлнэ."

**4/ 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

"8.2 Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөр зуучлалын алба нь хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр ажилд зуучлах үйлчилгээ гүйцэтгэж болох бөгөөд хөдөлмөрийн зах зээлийн болон ажилд зуучилсан үйл ажиллагаатай холбогдсон тайлан, мэдээг хөдөлмөр эрхлэлтийн албанд ирүүлнэ."

**5/ 9 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэг:**

"9.2 Мэргэжлийн сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд тулгуурлан ажил олгогчдын хэрэгцээ, захиалга, гэрээний үндсэн дээр зохион байгуулна. Сургалт нь албан ба албан бус, зайны, оройн ээлжийн эзрэг хэлбэртэй байх бөгөөд тэдгээрийг энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан сангийн, эсхүл ажилгүйдлийн даатгалын сангийн, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний зардлаар зохион байгуулж болно. Суралцагчийн тээврийн болон хоолны зардлын тодорхой хэсгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлж болно.

9.4 Хөгжлийн бэрхшээлтэй болон насанд хүрээгүй иргэнд мэргэжлийн сургалтаар мэргэжил эзэмшүүлэх, мэргэжлийн сургалтад хамрагдсан иргэнд хуулийн 13 дугаар зүйлд заасан сангаас тээвэр, хоолны болон сургалтын зардал олгох журам, түүнчлэн сургалтын зардлын дээд хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мэргэжлээр нь ялгавартайгаар тогтооно."

**6/ 10 дугаар зүйл:**

**"10 дугаар зүйл.Хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэнийг дэмжих**

10.1.Хувиараа болон өрхийн аж ахуй, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хүсэгч энэ хуулийн 3.1.1-д заасан иргэн, түүнчлэн малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дараахь дэмжлэг үзүүлнэ:

10.1.1.аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах;

10.1.2.үйлдвэрлэл, үйлчилгээгээ эхлэх болон шинээр ажлын байр бий болгох, өргөтгөхөд нь зориулан зээл олгох;

10.1.3.бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулах;

10.1.4.төсөл, хөтөлбөр боловсруулахад нь арга зүйн зөвлөлгөө өгөх, мэдээллээр хангах.

10.2.Энэ хуулийн 10.1.2-т заасан зээлийн хүүгийн хэмжээ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мөнгөн хөрөнгийг байршуулсан банк, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн хүүгийн доод түвшинтэй тэнцүү байна.

10.3.Энэ хуулийн 10.1-д заасан иргэнд материал, түүхий эд, үр, бордоо, мал, тэжээвэр амьтан, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл зэргийг худалдан авахад нь зориулж нэг сая хүртэл төгрөгийн зээлийг 1 жил хүртэл хугацаагаар олгож болно.

10.4. Энэ хуулийн 10.3-т заасан зориулалт, нөхцөлөөр олгосон зээлийн хүүг энэ хуулийн 10.2-т заасан банк, банк бус санхүүгийн байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн төлнө.

10.5.Нөхөн төлөх зээлийн хүүгийн хэмжээ тухайн банк, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн хүүгийн хэмжээнээс ихгүй байна.

10.6.Энэ хуулийн 10.1.-10.5-д заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах журмыг Засгийн газар батална."

**7/ 11 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг:**

"11.1. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй дор дурдсан иргэнийг 6 сараас доошгүй хугацаагаар ажиллуулж байгаа ажил олгогчид тус албатай байгуулсан гэрээний дагуу

нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолтыг үндэслэн тухайн ажилтанд эхний 6 сарын хугацаанд олгосон цалин, хөлсний 60 хувийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн олгоно:

11.1.1. 16 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг /;

11.1.2.хөгжлийн бэрхшээлтэй болох нь холбогдох журмын дагуу тогтоогдсон бөгөөд хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан иргэн;

11.1.3. 45-аас дээш насны ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн;

11.1.4.ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг тухайн онд төгссөн хөгжлийн бэрхшээлтэй болон бүтэн өнчин хүүхэд;

11.1.5. хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлснээс хойш нэг жилээс дээш хугацаагаар ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн.

11.3. Шинээр ажлын байр бий болгож энэ хуулийн 3.1.1 болон 3.1.4-т заасан иргэнийг авч ажиллуулсан аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл олгож болно."

**8/ 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

"12.2.Тухайн орон нутгийн зам, гүүр, далан, суваг, худаг, усжуулалтын системийг байгуулах, засварлах, ой, голын сав, төв суурин газрын бохирдлыг цэвэрлэх зэрэг нийтийг хамарсан ажлыг Засаг даргын тамгын газар, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотойгоор хөдөлмөр эрхлэлтийн алба зохион байгуулна."

**9/ 15 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:**

"15.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг дор дурдсан үйлчилгээ, арга хэмжээнд зарцуулна:

15.1.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох;

15.1.2.ажилд зуучлах;

15.1.3.мэргэжлийн сургалтад хамруулах;

15.1.4.нийтийг хамарсан ажил зохион байгуулах;

15.1.5 ажил олгогчийг дэмжих;

15.1.6 хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

15.1.7, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох;

15.1.8 хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээг турших, нэвтрүүлэх.

15.2 Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлогоос төвлөрүүлсэн хөрөнгийг Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу зарцуулна."

**10/ 21 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг:**

"21.2.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн

тухай хуулийн 45.1-д заасны дагуу нэр дэвшүүлсэн хүмүүсээс сонгож, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албаны даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.

21.3. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн алба нь улсын төсвөөс санхүүжинэ."

**3 дугаар зүйл.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.4 дэх хэсгийн "хөдөлмөрийн гэрээ" гэснийг "хөлсөөр ажиллах гэрээ" гэж, 14.1.7, 15.2-ын дугаарыг "14.1.8.", "15.3." гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Ц.НЯМДОРЖ**

**2006 оны 1 дүгээр  
сарын 12-ны өдөр**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**Улаанбаатар  
хот**

**ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "улсын төсөвт" гэснийг "хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд", "хүнд зориулах нийгмийн хамгааллын" гэснийг "хүний

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Ц.НЯМДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**2006 оны 1 дүгээр  
сарын 12-ны өдөр**

**Улаанбаатар  
хот**

**АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Аудитын тухай хуулийн 3, 4, 5, 7, 12, 14, 24, 25 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай заалт, хэсэг нэмсүгэй:

болон үндэсний стандартад нийцүүлэн баталж, тухайн байгууллагад мөрдөх баримт бичгийг.

**1/ 3 дугаар зүйлийн 10, 11, 12, 13 дахь заалт:**

13"ажлын баримт" гэж аудитын үйл ажиллагаа явуулах явцад цугларсан санхүүгийн баримтын хуулбар, бүртгэл, тооцоо, тайлан, судалгаа шинжилгээний материал, уулзалтын тэмдэглэл, мэдээлэл зэрэг аудитын үйлчилгээний дотоод стандартын дагуу бүрдүүлсэн баримт бичгийг."

"10"аудитын олон улсын стандарт" гэж Олон улсын нягтлан бодогчдын холбооноос баталсан аудитын үйл ажиллагааг эрхлэн явуулах зарчим, горимыг тусгасан баримт бичгийг;

**2/ 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:**

11"аудитын стандарт" гэж эрх бүхий байгууллагаас аудитын олон улсын стандартын зарчимд нийцүүлэн баталсан баримт бичгийг;

"2.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан аудитын үйл ажиллагаа нь төрийн байгууллагаас хийх хяналт шалгалтыг орлохгүй."

12"аудитын үйлчилгээний дотоод стандарт" гэж аудитын байгууллагаас олон улсын

**3/ 5 дугаар зүйлийн 8 дахь заалт:**

"8/аж ахуйн нэгж, байгууллагын тайланг 3 жил дараалан хянаж баталгаажуулсан аудитын байгууллага нь дахин тухайн аж ахуйн нэгж, байгууллагад 3 жилийн хугацаанд аудитын үйл ажиллагаа явуулахгүй."

**4/ 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11 дэх заалт:**

"11/энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-10-т заасан аж ахуйн нэгж, байгууллагатай адилтгах байгууллага."

**5/ 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

"3.Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн жилийн тайлангаа дараахь хугацаанд аудитын байгууллагаар баталгаажуулна:

1/ хувьцаат компани санхүүгийн жилийн тайлан хэлэлцэх хувьцаа эзэмшигчдийн хурлын өмнө;

2/ өөрчлөн байгуулагдаж, татан буугдаж байгаа болон бүх хөрөнгөө дуудлага худалдаагаар худалдах гэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага тухайн ажиллагааг хэрэгжүүлж эхлэхээс 1 сарын өмнө;

3/ бусад аж ахуйн нэгж, байгууллагууд санхүүгийн жилийн тайланг дараа оны эхний улиралд багтаан."

**6/ 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

"2.Нягтлан бодогчоос бусад мэргэжил эзэмшсэн иргэн дараахь шаардлагыг хангана:

1/их, дээд сургуулийн стандартын дагуу нягтлан бодогчийн мэргэжил эзэмшүүлэх сургалтын цагийг дүүргэсэн;

2/нягтлан бодогчоор 4-өөс доошгүй жил ажилласан."

**7/ 14 дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэг:**

"5.Олон улсын мэргэжлийн байгууллагаас Монгол Улсад болон гадаад оронд зохион байгуулсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад тэнцсэн иргэнд мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хугацаагүй олгох журмыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.Мэргэшсэн нягтлан бодогчоос өөр этгээд мэргэшсэн нягтлан бодогчийн зэрэг дэвийг ашиглахыг хориглоно."

**8/ 24 дүгээр зүйлийн 2 дахь**

**хэсэг:**

"2.Аудитын байгууллагаас өөр хуулийн этгээд "аудит" гэсэн үг буюу түүнтэй ижил төсөөтэй, бусдыг төөрөгдүүлэхээр үгийг нэрэндээ хэрэглэхийг хориглоно."

**9/25 дугаар зүйлийн 6, 7 дахь заалт:**

"6/ аудитын үйлчилгээний дотоод стандарттай байх;

7/ аудитын байгууллагыг үүсгэн байгуулагч нь гадаадын иргэн бол тухайн байгууллагын нийт ажиллагсдын 70-аас доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх."

**2 дугаар зүйл.** Аудитын тухай хуулийн 4, 12, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн өмнө "1." гэсэн дугаар, 25 дугаар зүйлийн 2 дахь заалтын "албан тушаалтан нь" гэсний дараа "мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хугацаагүй авсан бөгөөд" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Аудитын тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйлийн 1, 3, 7 дахь заалт:**

"1/аудитын үйл ажиллагаа" гэж аудитын байгууллагаас гэрээний дагуу хуулийн этгээд, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний нягтлан бодох бүртгэлийн хөтөлөлт, үйл ажиллагааны болон татварын тайланг хянаж дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг;

3/аудитор" гэж энэ хуульд заасан шаардлагыг хангаж, аудитын байгууллагад аудитын үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэшсэн нягтлан бодогчийг;

7/санхүүгийн баримт" гэж нягтлан бодох бүртгэлийн данс, өмч, хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлагын анхан шатны баримт ба нэмэлт тайлбар, тодруулга болон бизнесийн байгууллагын санхүү, эдийн засгийн асуудалтай холбоо бүхий баримт бичгийг;"

**2/ 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4, 6, 9 дэх заалт:**

"3/ 50 сая, түүнээс дээш төгрөгийн актив бүхий аж ахуйн нэгж, байгууллага;

4/өөрчлөн байгуулагдаж, татан буугдаж байгаа болон бүх хөрөнгөө дуудлагын худалдаагаар худалдах гэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;

6/хадгаламж, эзэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоо;

9/ Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан сан."

### 3/ 8 дугаар зүйл:

#### "8 дугаар зүйл. Аудитын стандарт

1.Аудитын үйл ажиллагаанд аудитын олон улсын стандартыг мөрдөнө.

2.Аудитын үндэсний стандартыг эрх бүхий байгууллага аудитын олон улсын стандартын зарчимд нийцүүлэн батална."

### 4/ 13 дугаар зүйл:

#### "13 дугаар зүйл. Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалт

1.Мэргэшсэн нягтлан бодогчдын институт нь мэргэшсэн нягтлан бодогч, аудиторчуудын мэргэжлийн ёс зүйг баталж, үндэсний хэмжээнд мөрдүүлэх эрх бүхий нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага мөн.

2.Мэргэшсэн нягтлан бодогчдын институт нь мэргэжлийн сургалт зохион байгуулах, мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалт авах, аудитын байгууллагыг арга зүйн удирдлага, зөвлөгөө, мэдээллээр хангах үйл ажиллагаа явуулна.

3.Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад тэнцсэн хүнд мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

4.Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтын журмыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

### 5/ 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг нэг дэх шатны шалгалтад тэнцсэн бол 2 жилийн хугацаатай, хоёр дахь шатны шалгалтад тэнцсэн бол 5 жилийн хугацаатай, гурав дахь шатны шалгалтад тэнцсэн бол хугацаагүй олгоно."

### 6/ 16 дугаар зүйлийн 3 дахь заалт:

"3/дараагийн шатны шалгалтад тэнцээгүй, эсхүл хүндэтгэх шалтгаангүйгээр уг шалгалтад ороогүй, нягтлан бодогчийн мэргэжлийн ёс зүйг зөрчсөн нь тогтоогдож, мэргэшсэн нягтлан бодогчийн эрх нь хасагдсан."

### 7/ 17 дугаар зүйл:

#### "17 дугаар зүйл. Аудитор

1.Дараахь шаардлагыг хангасан мэргэшсэн нягтлан бодогч аудитын байгууллагад аудиторор ажиллана:

1./мэргэшсэн нягтлан бодогчийн хоёр, гурав дахь шатны шалгалтад тэнцсэн;

2/нягтлан бодогчийн мэргэжил эзэмшсэнээс хойш мэргэжлийн ёс зүйг зөрчөөгүй;

3/аудитын байгууллагад 3-аас доошгүй жил аудиторын туслагчаар ажилласан.

2.Аудитор нь аудитын үйл ажиллагааг аливаа этгээдээс хараат бусаар хэрэгжүүлнэ."

### 8/ 26 дугаар зүйл:

#### "26 дугаар зүйл.Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

1.Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

1/тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл;

2/тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;

3/аудиторуудын товч анкет;

4/аудитын байгууллага үүсгэн байгуулах шийдвэр;

5/аудитын байгууллагын дүрэм;

6/ аудитын үйлчилгээний дотоод стандарт.

2.Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай<sup>1</sup> хуульд заасны дагуу олгоно.

### 9/ 29 дүгээр зүйлийн 3 дахь заалт:

"3/нягтлан бодох бүртгэлийг нь хөтөлж, тайланг гаргасан."

### 10/ 30 дугаар зүйл.

"30 дугаар зүйл. Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

<sup>1</sup> Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны №6 –д нийтлэгдсэн

1. Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь нөхцөлд санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр хүчингүй болгоно:

1/нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандартын дагуу ажлын баримт бүрдүүлээгүй;

2/аудитын чанарын хяналт хийхэд албаны байр, ажлын баримт материал, бусад шаардлагатай мэдээлэл үзүүлэхээс зайлсхийсэн;

3/санхүүгийн тайланг хуурамчаар баталгаажуулсан нь нотлогдсон;

4/энэ хуульд заасан аудитын байгууллагад тавигдах шаардлагыг хангаж ажиллаагүй.

2. Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бол энэ тухай түүнийг бүртгэсэн улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ. "

**4 дүгээр зүйл.** Аудитын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалтын "хуримтлагдсан ашгийн тайлан" гэснийг "өмчийн өөрчлөлтийн тайлан", 8 дахь заалтын "байгууллагыг" гэснийг "байгууллага, түүнчлэн компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/, эсхүл компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчдийг.", 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "баримтыг" гэснийг

"тайланг", "шалгаж" гэснийг "хянаж" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1, 4 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсын", 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн", мөн зүйлийн 2, дахь хэсгийн "Мэргэжлийн зөвлөлийн дарга" гэснийг, 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийг тус тус хассууяй.

**6 дугаар зүйл.** Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 6 дахь заалт, 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 4 дүгээр бүлгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.** Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4, 5, 6, 7, 8, 9 дэх заалтын дугаарыг "2", "3", "4", "5", "6", "7", "8" гэж, 15 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн дугаарыг "2", "3" гэж, 22 дугаар зүйлийн 4, 5, 6, 7 дахь хэсгийн дугаарыг "3", "4", "5", "6" гэж, Тавдугаар бүлгийн дугаарыг "Дөрөвдүгээр бүлэг" гэж, 37, 38, 39, 40 дүгээр зүйлийн дугаарыг "31", "32", "33", "34" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 19, 20, 21 дэх заалт:**

"3.1.19. "эмнэлгийн багаж" гэж хүний бие махбодын бүтэц, үйл ажиллагаа, эмгэг, согогийг оношлох, эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, хянах зориулалтаар бүтээгдсэн болон гараар хийх үйлдэлд хэрэглэгдэх зүйлийг;

3.1.20. "протез" гэж хүний эд эрхтнийг орлуулах болон эмгэг, согогийг засах зориулалтаар бүтээгдсэн зүйлийг;

3.1.21. "биологийн идэвхт бүтээгдэхүүн" гэж хүний бие махбодын үйл ажиллагааг дэмжих, шаардлагатай бодис, илчлэгийг нөхөх үйлчилгээ бүхий бүтээгдэхүүнийг."

**2/ 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8, 9 дэх заалт:**

"8.1.8. эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж;

8.1.9. эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах, тэдний нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, шийдвэрийн биелэлтийг хангуулах;"



## 3/ 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, 7 дахь заалт:

"10.1.6. эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа байгууллага, хамт олон, аж ахуйн нэгжийг урамшуулах, сурталчилах ажлыг зохион байгуулах;

10.1.7. орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;"

## 4/ 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

"11.4. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх, зохион байгуулах, хянах үүргийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газраар гүйцэтгүүлэх бөгөөд аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

## 5/ 21 дүгээр зүйлийн 3, 4, 5 дахь хэсэг:

"21.3. Эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт болон журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.4. Улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж, үйлчилгээ, тэдгээрийг санхүүжүүлэх арга, төлбөрийн хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоох бөгөөд уг тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгох журмыг Засгийн газар батална.

21.5. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт тусламж, үйлчилгээ үзүүлднээс олсон орлогыг эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрийн хэвийн нөхцөл, нийгмийн баталгааг хангахад зарцуулах бөгөөд журмыг нь сангийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална."

## 6/ 26<sup>1</sup> дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"26<sup>1</sup>.1.3. сум, тосгон, сум дундын эмнэлэгт 3-аас дээш жил тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнийг төрийн зардлаар төгсөлтийн дараахь мэргэшүүлэх сургалтад хамруулах, их эмчид 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний

мөнгөн тусламжийг ажиллаж байгаа эрүүл мэндийн байгууллагаас олгох;"

## 7/ 26<sup>1</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"26<sup>1</sup>.2. Энэ хуулийн 26<sup>1</sup>.1.1-д заасан тусламж олгох журам, үг тусламжид хамрагдах эмнэлгийн мэргэжилтний жагсаалтыг эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална."

## 8/ 28<sup>1</sup> дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, 7 дахь заалт:

"28<sup>1</sup>.1.6 удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардал;"

28<sup>1</sup>.1.7. эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ."

## 9/ 44 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"44.3. Энэ хуулийн 44.2-т заасан баримт бичигт тухайн бүтээгдэхүүний материалын бүтэц, чанар, техникийн болон бусад үзүүлэлт, баталгаат хугацаа, засвар, үйлчилгээ хийх болон сэлбэг хэрэгсэл, урвалж бодисоор хангах нөхцөлийг тусгасан байна."

## 10/ 44<sup>1</sup> дугаар зүйл:

"44<sup>1</sup> дугаар зүйл. Ахуйн шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ болон биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх үйлчилгээ

44<sup>1</sup>.1. Ахуйн шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ болон биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх үйлчилгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд эрхэлнэ."

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1-ийн "эм хангамжийн," гэсний дараа "анагаах ухааны боловсрол," гэж, 23.3-ийн "дүрэм" гэсний дараа "анагаах ухааны" гэж, 26.1.3-ын "үйлчилгээ үзүүлэх" гэсний дараа "удирдамж," гэж, 28.2-ын "давтан сургах" гэсний дараа "мэргэшлийн зэрэг олгох" гэж, 42.3-ын "Эмнэл зүйн туршилт явуулах," гэсний дараа "судалгаа, шинжилгээний зорилгоор хүний цус, цусан бүтээгдэхүүн, биологийн шингэн, эд, эрхтэн авах, хэрэглэх" гэж, 51.1.7-ын "36.1" гэсний дараа "44.44" гэж, 51.1.11-ийн "Энэ хуулийн" гэсний дараа "15.1.4," гэж, "28.1" гэсний дараа "29.2, 34.1," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай

хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

## 1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 18 дахь заалт:

"3.1.18. "Эмнэлгийн тоног тохөөрөмж" гэж хүний бие махбодын бүтэц, үйл ажиллагаа, эмгэг, согогийг оношлох, эмчлэх, нөхөн сэргээх, хянах зориулалтаар бүтээгдсэн бие даасан ажиллагаа бүхий зүйлийг."

## 2/ 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"8.1.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, үйлдвэрлэлийн стандартыг боловсруулж эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх, хөдөлмөрийн норм, нормативыг ажиглны эрх, ашиг сонирхолыг төлөөлөх байгууллагын саналыг харгалзан төрийн захиргааны холбогдох төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтийг зохион байгуулах;"

## 3/ 16 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг:

"16.1. Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллага нь эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи, чанарт хөндлөнгийн шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.

16.2. Эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон төрийн байгууллага, шинжээч хэрэгжүүлнэ.

16.3 Магадлан итгэмжлэх, шинжээч ажиллуулах журам, магадлан шинжлэх шалгуур, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

## 4/ 17 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг:

"17.1. Анагаах ухааны болон эм зүй, сувилахуйн боловсрол олгох тусгай зөвшөөрөл бүхий сургууль төгссөн эмч, сувилагч, эм зүйч, эм найруулагчид олгох мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл нь эмчлэх, сувилах, эм барих гэсэн төрөлтэй байна.

17.2. Эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

17.3.Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг өрхийн, сум, сум дундын эмнэлэгт 2-оос доошгүй жил дадлагатгаар ажиллаж

мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн эмнэлгийн мэргэжилтэнд олгоно.

17.4. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, дадлагажгаачаар ажиллуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

## 4/ 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"34.2. Нарийн төвөгтэй оношлогоо, мэс засал хийх, анагаах ухааны судалгаа, туршилтад оролцуулах бол тухайн иргэнээс, 18 насанд хүрээгүй хүүхэд, сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүй болох нь тогтоогдсон өвчтөний тухайд хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс нь бичгээр зөвшөөрөл авна."

## 5/ 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"35.2. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн мэргэжлийн тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцна."

## 6/ 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"44.2. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, худалдах, импортлоход тухайн бүтээгдэхүүний техникийн болон чанарын баталгаажуулалтын баримт бичгийг хавсаргасан байна."

## 4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай

хуулийн 17 дугаар зүйлийн гарчгийг "Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох" гэж, 22.2-ын "эмнэлгийн мэргэжилтэн" гэснийг "сувилагч" гэж, 22.3-ын "эмнэлгийн мэргэжилтэн" гэснийг "эм зүйч, эм найруулагч" гэж, 28.2-ын "эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд" гэснийг "эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дангаар буюу холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай" гэж, 28<sup>1</sup> дүгээр зүйлийн гарчгийг "Төрөөс төлбөрийг нь хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээ" гэж, 28<sup>1</sup>.1-ийн "үйлчилгээг төлбөргүй үзүүлнэ" гэснийг "үйлчилгээний төлбөрийг төр хариуцна" гэж, 28<sup>1</sup>.2-ын "төлбөргүй" гэснийг "төрөөс төлбөрийг нь хариуцах" гэж, 28<sup>1</sup>.2-ын "28<sup>1</sup>.1.2-т заасан өвчин эмгэгийн жагсаалтыг" гэснийг "28<sup>1</sup>.1.6-д заасан өвчин эмгэгийн жагсаалт болон төр хариуцах зардлын хэмжээг" гэж, 44 дүгээр зүйлийн гарчиг болон 44.1-ийн "хэрэгсэл" гэснийг "багаж, тоног төхөөрөмж, протез" гэж, "8.1.8" гэсэн заалтын дугаарыг "8.1.10", "10.1.6" гэсэн заалтын дугаарыг "10.1.8", "26<sup>1</sup>.1.3." гэсэн заалтын дугаарыг "26<sup>1</sup>.1.4." гэж тус тус өөрчилсүгэй.

## 5 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай

хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "мэргэжлийн хяналтын", 28<sup>1</sup>.1.2 дахь заалтаас "болон удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах зарим" гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 26<sup>1</sup>.1.3 дахь заалтын "5 жил тутамд" гэсэн хугацааг энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тооцно.

хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

### АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

**1/15 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн 8,9,10 дахь заалт:**

"15.12.8.ахуйн шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх;

15.12.9.биологийн идэвхт үйлчилгээтэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх үйлчилгээ эрхлэх;

15.12.10.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд эмчилгээний гоо заслын үйлчилгээ эрхлэх."

**2/16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалт:**

"16.2.6.эмчилгээний гоо заслын үйлчилгээ."

**2 дугаар зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.12.2-ын "эмнэлгийн хэрэгсэл" гэсний дараа "багаж, тоног төхөөрөмж, протез", мөн заалтад "худалдах" гэсний дараа "импортлох" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр  
сарын 27-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт дор дурдсан агуулга бүхий 20 дахь заалт нэмсүгэй:

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2006 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

"9.2.20. үйлдвэрийн аргаар боловсруулж дотоодод борлуулсан мах"

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨВИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ДАМЖУУЛАЛТЫН СҮЛЖЭЭГ ШИНЭЧЛЭН ЗАСВАРЛАХ ТӨСЛИЙН БУЦАЛТҮЙ ТУСЛАМЖ, ХҮҮГҮЙ ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Швед Улсын Свенск Экспорткредит корпорацийн хооронд 2005 оны 10 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан "Төвийн эрчим хүчний дамжуулалтын сүлжээг шинэчлэн засварлах төслийн буцалтгүй тусламж, хүүгүй зээлийн хэлэлцээр"-ийг Монгол

Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ОРОН НУТГИЙН ЗАМ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын Зээлийн банк хооронд 2005 оны 7 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан "Орон нутгийн зам сайжруулах төслийн зээлийн хэлэлцээр"-ийг

Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

### Мөнгөн тэмдэгтийн загвар, тодорхойлолт батлах тухай

Монгол Улсын Төв Банк / Монголбанк /-ны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

төгрөгийн мөнгөн тэмдэгтийн загвар, тодорхойлолт"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

"Гүйлгээнд гаргах 20000 төгрөгийн мөнгөн тэмдэгтийн загвар, тодорхойлолт"-ыг 1 дүгээр, "Дурсгалын мөнгөн тэмдэгт болгон гаргах 20000

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Ц.НЯМДОРЖ**

*Монгол Улсын Их Хурлын 2006 оны 06 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт*

### ГҮЙЛГЭЭНД ГАРГАХ 20000 ТӨГРӨГИЙН МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ЗАГВАР, ТОДОРХОЙЛОЛТ

1. Мөнгөн тэмдэгтийн урт нь 150 мм, өргөн нь 72 мм байна.  
2. Мөнгөн тэмдэгтийн өвөр талд дараахь дүрс, үг, үсэг хэвлэнэ:

- 2.1. Чингис хааны хөрөг;
- 2.2. "CHINGGIS KHAAN" гэсэн бичиг;
- 2.3. соёмбо;
- 2.4. Чингис хааны зарлигийн пайз;
- 2.5. морь унасан 4 баатрын дүрс;

2.6. араб, уйгаржин тоогоор бичсэн

"20000" гэсэн мөнгөн тэмдэгтийн нэрлэсэн үнэ;

2.7. уйгаржин үсгээр бичсэн "Монгол Улс", "хорин мянган төгрөг", "Монголбанк" гэсэн бичиг;

2.8. уйгаржин үсгээр бичсэн "Монголбанкны Ерөнхийлөгч" гэсэн бичиг;

2.9. Монголбанкны Ерөнхийлөгчийн гарын үсэг;

2.10. түмэн насан хээ зэрэг үндэсний хээ угалз ;

2.11. мөнгөн тэмдэгтийн серийн дугаар.

3.2 Чингис хааны зарлигийн пайз;  
3.3. кирилл үсгээр бичсэн "МОНГОЛ УЛС", "ТӨГРӨГ", "МОНГОЛБАНК" гэсэн үгнүүд;

3. Мөнгөн тэмдэгтийн ар талд дараахь дүрс, үг, үсэг хэвлэнэ:

3.4. араб, уйгаржин тоогоор бичсэн "20000" гэсэн мөнгөн тэмдэгтийн нэрлэсэн үнэ;  
3.5. хэвлэсэн он /2006/.

3.1. Есөн хөлт Их цагаан туг;

*Монгол Улсын Их Хурлын 2006 оны 06 дугаар*

*тогтоолын 2 дугаар хэсэрлэлт*

## ДУРСГАЛЫН МӨНГӨН ТЭМДЭГТ БОЛГОН ГАРГАХ 20000 ТӨГРӨГИЙН МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ЗАГВАР, ТОДОРХОЙЛОЛТ

1. Мөнгөн тэмдэгтийн урт нь 150 мм, өргөн нь 72 мм байна.

2.10. түмэн насан хээ зэрэг үндэсний хээ угалз;

2. Мөнгөн тэмдэгтийн өвөр талд дараахь дүрс, үг, үсэг хэвлэнэ:

2.11. мөнгөн тэмдэгтийн серийн дугаар;

- 2.1. Чингис хааны хөрөг;
- 2.2. "CHINGGIS KHAAN" гэсэн бичиг;
- 2.3. соёмбо;
- 2.4. Чингис хааны зарлигийн пайз;
- 2.5. морь унасан 4 баатрын дүрс;
- 2.6. араб, уйгаржин тоогоор бичсэн "20000" гэсэн мөнгөн тэмдэгтийн нэрлэсэн үнэ ;

2.12. англи хэлээр бичсэн "Их Монгол Улс 1206-2006, 800 жил" гэсэн бичиг.

2.7. уйгаржин үсгээр бичсэн "Монгол Улс", "хорин мянган төгрөг", "Монголбанк" гэсэн бичиг;

3. Мөнгөн тэмдэгтийн ар талд дараахь дүрс, үг, үсэг хэвлэнэ:

2.8. уйгаржин үсгээр бичсэн "Монголбанкны Ерөнхийлөгч" гэсэн бичиг;

3.1. Есөн хөлт Их цагаан туг;

2.9. Монголбанкны Ерөнхийлөгчийн гарын үсэг;

3.2. Чингис хааны зарлигийн пайз;

3.3. кирилл үсгээр бичсэн "МОНГОЛ УЛС", "ТӨГРӨГ", "МОНГОЛ БАНК" гэсэн үгнүүд;

3.4. араб, уйгаржин тоогоор бичсэн "20000" гэсэн мөнгөн тэмдэгтийн нэрлэсэн үнэ;

3.5. хэвлэсэн он /2006 /;

3.6. уйгаржин үсгээр бичсэн "Их Монгол Улс 800 жил" гэсэн бичиг.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 20—ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

### Үндэсний статистикийн газрын дарга, дэд даргад зэрэг дэв олгох журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 8.1.2, 28.2.3 дахь заалт, Статистикийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үндэсний статистикийн газрын дарга, дэд даргын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг хэвсрэлтээр баталсугай.

2. Үндэсний статистикийн газрын дарга, дэд даргад зэрэг дэвийн нэмэгдэл олгоход шаардагдах зардлыг Үндэсний статистикийн газрын жил бүрийн төсөвт тусгаж байхаар тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц. НИЯМДОРЖ

*Монгол Улсын Их Хурлын 2006 оны 08 дугаар тогтоолын хэсэрлэлт*

### ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗРЫН ДАРГА, ДЭД ДАРГИЙН ЗЭРЭГ ДЭВ, ТҮҮНИЙ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Энэ журмаар Үндэсний статистикийн газрын дарга, дэд даргын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох асуудлыг зохицуулна.

2. Үндэсний статистикийн газрын дарга, дэд даргад Тэргүүн түшээ, дэд түшээ зэрэг дэв олгоно.

3. Үндэсний статистикийн газрын дарга, дэд даргад зэрэг дэв олгоход албан тушаал, төрийн алба хаасан хугацаа, урьд нь олгогдсон зэрэг дэв, ажил хэргийн чадварыг харгалзана.

4. Үндэсний статистикийн газрын дарга, дэд даргын зэрэг дэвийг Үндэсний статистикийн газрын зөвлөлийн санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч олгоно.

5. Тэргүүн түшээ зэрэг дэвийн нэмэгдлийг үндсэн цалингийн 25 хувиар, дэд түшээ зэрэг дэвийн нэмэгдлийг үндсэн цалингийн 23 хувиар тус тус тооцож, сар тутамд олгоно.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

### Улсын Их Хурлын 2006 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Байнгын хороодоос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2006 оны хаврын ээлжит чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсөгүй.

1/Авилгалын эсрэг хуулийн төсөл, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд, "Улсын Их Хурлын 2002 оны 41 дүгээр тогтоолын зарим заалт, хавсралтыг хүчингүй болгох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

2/Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

3/Монгол Улсын татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн орлогын албан татварын хуулийн шинэчилсэн найруулга, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүн амын орлогын албан татварын хуулийн шинэчилсэн найруулга, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, "Тогтоолд нэмэлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

4/Улсын Их Хурлын гишүүдээс болон Засгийн газраас санаачилсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах

тухай, Олборлон боловсруулж байгаа зарим төрлийн ашигт малтмалд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

5/Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

6/Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн төсөл;

7/Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл;

8/Ашигт малтмалыг гар үйлдвэрлэлийн аргаар олборлох тухай хуулийн төсөл;

9/Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

10/Чингис хааны нэрийг хэрэглэх тухай хуулийн төсөл;

11/Төрийн дээд шагналын тухай хуулийн төсөл;

12/Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

13/Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай зэрэг хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

14/Боловсролын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

15/Батлан хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

16/Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

17/Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

18/Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

19/Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

20/Хадгаламжийн даатгалын тухай хуулийн төсөл;

21/Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банкны тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд;

22/"40000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зарим хуулийн заалтыг хамааруулахгүй байх тухай, Орон сууцны тухай хуульд нэмэлт оруулах тухай, "40000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зарим газрын эзэмших эрхийн гэрчилгээ шилжүүлэх хэлбэрийн тухай хуулийн төслүүд, "Зөвшөөрөл олгох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

23/"Монгол Улсын 2005 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

24/"Монгол Улсын 2007 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

25/"Эртний нийслэл Хархорумыг жишиг хот болгон хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

26/"Сэлэнгэ мөрөн, Онон, Балж голд урсацын тохируулга хийх замаар усны зохих хэсгийг говь, хээрийн бүс рүү шилжүүлэх санал боловсруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

27/Бусад.

2. Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр энэ тогтоолд дурьдаагүй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчдаас өгөн мэдүүлбэл энэ оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Улсын Их Хурлын даргад зөвшөөрсүгэй.

3. Улсын Их Хурлын 2006 оны хаврын чуулганы явцад өгөн мэдүүлсэн бусад хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг тухайн үед нь шийдвэрлэж байхаар тогтоосугай.

4. Улсын Их Хурлын 2006 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Засгийн газар, Байнгын хороодын дарга нар болон Тамгын газар /Н.Лувсанжав/-т тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Раднаасүмбэрэлийн Гончигдорж, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Агыпарын Бакей, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинэчлэх ухааны байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Төгсжаргалын Гэнди, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн

Долцонгийн Дондог, Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Чүлтэмийн Улаан, Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Лувсанямын Гантөмөр нарыг тус тус сонгосугай.

2. Энэ тогтоолыг 2006 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс охлон дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 28—ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

### Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх заалт, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын гишүүн, сайдаар дор дурдсан хүмүүсийг томилсугай:

1/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын шадар сайдаар Мэндсайханы Энхсайханыг;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайдаар Ичинхорлоогийн Эрдэнэбаатарыг;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдаар Жанлавын Наранцацралтыг;

4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар Мишигийн Сономпилыг;

5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдаар Өлзийсайханы Энхтүвшинг;

6/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад хэргийн сайдаар Нямаагийн Энхболдыг;

7/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам тээвэр, аялал жуулчлалын сайдаар Цэцэгмидийн Цэнгэлийг;

8/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдаар Лувсангийн Одончимэдийг;

9/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар Надмидын Баяртсайханыг;

10/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Түлш, Эрчим хүчний сайдаар Бадарчийн Эрдэнэбатыг;

11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, худалдааны сайдаар Базарсадын Жаргалсайханыг;

12/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар Доржийн Одбаярыг;

13/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар Дэндэвийн Тэрбишдавыг;

14/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар Ламжавын Гүндалайг;

15/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар Сундуйн Батболдыг;

16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдаар Ухнаагийн Хүрэлсүхийг.

2. Энэ тогтоолыг 2006 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 28—ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

### Засгийн газрын гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Чүлтэмийн Улааныг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын шадар сайдын,

Уламбаярын Барсболдыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайдын;

Нямжавын Батбаярыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдын;

Цэрэнхүүгийн Шаравдоржийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдын;



Пунцагийн Цагааныг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын;

Цэндийн Мөнх-Оргилыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад хэргийн сайдын;  
Гаваагийн Батхүүг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам тээвэр, аялал жуулчлалын сайдын;

Цэвэлмаагийн Баярсайханыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын;

Норовын Алтанхуягийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдын;

Түвдэнгийн Очирхүүг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Түлш, эрчим хүчний сайдын;

Сүхбаатарын Батболдыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, худалдааны сайдын;

Сундуйн Батболдыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын;

Дэндэвийн Тэрбишдавыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын;

Төгсжаргалын Гандийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдын;

Сангажавын Баярцогтыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Сайд-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын;

Ухнаагийн Хүрэлсүхийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын;

Дамбийн Дорлигжавыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2006 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

**Ц.Элбэгдоржийг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Цахиагийн Элбэгдоржийг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2006 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

**Монгол Улсын Ерөнхий сайд асан Ц.Элбэгдоржийн хамгаалалт, хангамжийн тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9 дэх заалт, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайдын алба хашиж байсан Ц.Элбэгдоржийг 1 жил 5 сарын хугацаанд хамгаалах ажлыг Төрийн тусгай хамгаалалтын газарт хариуцуулсугай.

2. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /М.Энхболд/-т даалгасугай.

1/энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан хугацаанд Ц.Элбэгдоржид Засгийн газраас тогтоосон журмын дагуу суудлын автомашинаар үйлчлэх;

2/Ц.Элбэгдоржид Улсын Их Хурлын 2005 оны 38 дугаар тогтоолоор тогтоосон цалин, бусад нэмэгдэлтэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг 6 сарын хугацаанд олгох;

3/энэ тогтоолын 2 дахь хэсгийн 2-т заасан хугацааны дотор ажил, албан тушаал эрхэлбэл томилогдсон ажил, албан тушаалын цалин, хөлс нь өмнөх тушаалынхаас бага байвал зөрүүг тооцож олгох.

3. Энэ тогтоолыг 2006 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 28—ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

### Зарим хүмүүст тэтгэлэг олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

тогтоомжоор тогтоосон цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэлэг олгохыг Засгийн газар / М.Энхболд/-т даалгасугай.

2. Энэ тогтоолыг 2006 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**
**Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 2 дугаар сарын 3—ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

### Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 15.3, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 6.1.1, Монгол Улсын 2006 оны төсвийн тухай хуулийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /М.Энхболд/-т даалгасугай.

1/ төрийн албан хаагчдын цалин, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг 2006 оны 2 дугаар сарын 1-нээс нэмэгдүүлэх;

2/ энэ тогтоолын 1 дэх хэсгийн 1-д заасан арга хэмжээнд нэмж шаардагдах 36.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Монгол Улсын 2006 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах хүртэлх хугацаанд батлагдсан төсвийн хэмжээнд зохицуулан шийдвэрлэж байх;

3/ Монгол Улсын 2006 оны төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын 2005 оны төсвийн гүйцэтгэл, 2007 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлтэй уялдуулан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2. Монгол Улсын 2006 оны төсөвт 84.0 тэрбум төгрөгийн орлого тооцогдож тусгагдаагүй шалтгааныг судалж дүнг Улсын Их Хуралд танилцуулахыг Төсвийн байнгын хороо /Ч.Улаан/-нд даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2006 оны 2 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**
**Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 12 дугаар сарын 7—ны өдөр

Дугаар 244

Улаанбаатар хот

### Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд П.Цагаанд даалгасугай.

3. Хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд Д.Дорлигжавт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Ц.ЭЛБЭГДОРЖ**
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**
**П.ЦАГААН**

*Засгийн газрын 2005 оны 244 дүгээр тогтоолын хавсралт*

### ҮНДЭСНИЙ СОЁЛЫН ӨВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ТООН СИСТЕМД ОРУУЛАН ХАДГАЛАХ ХӨТӨЛБӨР

#### Нэг. Хөтөлбөрийн эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуульд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж

заасан бөгөөд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Түүх, соёлын үл хөдлөх

дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах Үндэсний хөтөлбөр эрэг баримт бичигт соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, судлах, сурталчлах, ашиглах талаар тодорхой заасан байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2004-2008)-ийн 2.4-т “Үндэсний дурсгалт соёлын өв хөрөнгийн талаархи мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр боловсруулан ажиллана” гэж заажээ.

## Хоёр. Хөтөлбөрийн үндэслэл

Соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах ажлын үндэс нь соёлын өвийг баримтжуулан бүртгэж, мэдээллийн санг бүрдүүлэх явдал юм.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сангийн тогтолцоо, улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, түүнд бүртгэх харилцааг зохицуулжээ. Энэхүү хуулийн дагуу 1995 онд Соёлын яамны (хуучин нэрээр) харьяанд Соёлын өвийн төв байгуулагдаж соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг “Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” (1995, 2005)-ын дагуу гүйцэтгэж иржээ.

Одоогийн байдлаар Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан нь 267 ширхэг түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл, нийслэл болон 20 аймгийн музейн үнэт үзмэр зэргээс бүрдсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт 6000 орчим зүйл, үл хөдлөх дурсгалт 400 орчим зүйлийг тодорхойлолт, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулан бүртгэлийг бүрдүүлэн хадгалжээ. Бүртгэлийн 70 орчим хувь нь орон нутгийн музейн үзмэрийн бүртгэл эзэлж байгааг үзэхэд түүх, соёлын нандин өв сан голлон хадгалж байгаа улсын чанартай музей, Эрдэнэсийн сан, Үндэсний номын сан, Гандантэгчичлэн хийд, Археологийн хүрээлэн зэргийн зөвхөн түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл нь бүртгэгдсэнээс бусад дурсгалт зүйл үндсэндээ улсын нэгдсэн бүртгэлгүй байна.

Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн сангийн бүрдүүлсэн дээрх бүртгэлийн гэрэл зураг, дүрс бичлэг, тодорхойлолт зэргийн зарим нь мэргэжлийн түвшинд хүрэхгүй байгаа нь тухайн байгууллагын боловсон хүчин, гэрэл зургийн тоног төхөөрөмж, хэмжилтийн багаж, компьютер түүний дагалдах хэрэгсэл дутмаг буюу огт байхгүйтэй холбоотой юм. Түүнчлэн соёлын өвийн мэдээллийг бүртгэх, хадгалах тусгай программ байхгүй, улс, аймгийн музей болон соёлын өв хадгалагдаж буй бусад байгууллага нь мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй байгаа учраас соёлын өвийн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх ажил удашралтай явагдаж байгаа юм.

Бүртгэл-мэдээллийн санд хадгалагдаж байгаа бүртгэл нь батлагдсан маягтын дагуу бөглөсөн тухайн дурсгалт зүйлийн тодорхойлолт, гэрэл зураг бүхий цаасан дээрх мэдээлэл нь

хэрэглэгчдээ тавьж буй шаардлагад бүрэн нийцэхгүй, хязгаарлагдмал шинжтэй байна. Иймд соёлын өвийн талаархи мэдээллийг тоон технологид оруулж электрон бичлэгтэй, хэмжээ, эргэлтийн хувьд хязгааргүй, орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэдээллийг түргэн шуурхай харилцан солилцох, хэрэглэгчдэд хүргэх боломжийг орчин үеийн техник, технологийг ашиглан бүрдүүлж, найдвартай хадгалах зайлшгүй шаардлага гарч байна.

Мэдээллийн эрин зуунд соёлын өвийн талаархи мэдээллийг багцлан хадгалахын тулд орчин үеийн компьютер, харилцаа холбооны техник ашиглан, мэдээллийн эрэлт хэрэгцээнд тохирсон тоон технологи, электрон хэлбэрт оруулж, олон улсын жишигт нийцсэн соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сүлжээг бий болгосноор соёлын өвийн талаархи бүх мэдээллийг түргэн хугацаанд солилцох, соёлын өвөө дэлхий нийтэд сурталчлах, улмаар найдвартай хадгалах нөхцөлийг бүрдүүлж мэдээллээ хойч үедээ өвлүүлэн үлдээх таатай боломж бий болох юм.

## Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

### 3.1. Хөтөлбөрийн зорилго

Үндэсний соёлын өвийн талаархи бүрэн мэдээллийг бүрдүүлэх, соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангийн тогтолцоог сайжруулж, соёлын өвийн мэдээллийг тоон технологи, электрон хэлбэрт оруулан нэгдсэн сүлжээ бий болгон, мэдээллийг шуурхай харилцан солилцох, найдвартай хадгалах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой.

### 3.2. Хөтөлбөрийн зорилтууд

3.2.1. соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулах програм хангамжтай болох;

3.2.2. соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан болон соёлын өвийг хадгалж байгаа байгууллагыг гэрэл зургийн тоног төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд ашиглагдах компьютер, дагалдах хэрэгсэлээр хангах;

3.2.3. програм хангамж, техник хэрэгсэл дээр ажиллах боловсон хүчинг бэлтгэх;

3.2.4. соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд соёлын өвийг бүрэн хамруулах. Үүнд:

а/улсын болон шашны байгууллагад хадгалагдаж байгаа түүх, соёлын хөдлөх дурсгал;

б/үл хөдлөх дурсгал;

в/утга соёлын өв.

3.2.5. үндэсний соёлын өвийн мэдээллийг улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд төвлөрүүлэн, архивлан хадгалах.

## Дөрөв. Хэрэгжүүлэх арга зам

4.1. соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулах програм хангамжийг боловсруулах мэргэжлийн баг ажиллуулах;

4.2. соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан болон соёлын өвийг хадгалж

байгаа байгууллагуудад гэрэл зургийн тоног төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд ашиглагдах компьютер, дагалдах хэрэгслийг суурилуулах;

4.3. техник хэрэгсэлд нь дадлагажуулах, баримтжуулах үйл ажиллагааг явуулах талаар тусгай сургалт-семинар зохион байгуулж, удирдамж, заавар, аргачлалаар хангах;

4.4. соёлын өвийн талаархи бүртгэл, мэдээллийг программын дагуу бүрдүүлж 2007 онд дуусгах, цаашид мэдээллийн баяжилт, шинэчлэлийг байнга хийж байх. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хуваарийн дагуу улиралд нэг удаа сүлжээгээр хүргүүлэх бөгөөд сүлжээний зардлыг тухайн жилийн төсөвт тусгаж байх;

4.5. соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд бүртгэлийг архивын зориулалтаар тоноглогдсон өрөөнд цаасан болон электрон хэлбэрээр архивлан хадгалах;

4.6. "Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, түүнд бүртгэх журам"-ын дагуу дурсгалыг 3-4 талаас нь авсан болон онцлог шинж, гэмтлийг харуулсан гэрэл зургууд, маягтын дагуу бүрдүүлсэн тодорхойлолт зэргээс мэдээллийг бүрдүүлэх;

4.7. үл хөдлөх дурсгалын мэдээллийг сүлжээнд нээлттэй тавьж сурталчлах;

4.8. хөдлөх дурсгалын мэдээллийн тодорхой хэсгийг судалгаа, сурталчилгаанд зориулах;

4.9. утга соёлын өвийн талаархи мэдээллийн нэг хувийг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд шилжүүлэн авч тоон системд оруулах.

## Тав. Хөтөлбөрийн хамрах хүрээ

### 5.1. Улсын чанартай музей:

1. Чойжин ламын сүм музей;
2. Богд хааны ордон музей;
3. Дүрслэх урлагийн музей;
4. Уран зургийн галерей;
5. Эрдэнэ зуу музей;
6. Үндэсний түүхийн музей;
7. Театрын музей;
8. Монгол цэргийн музей;
9. Байгалийн түүхийн музей.

### 5.2. Орон нутгийн чанартай музей:

21 аймгийн музей.

5.3. Соёлын өв хадгалагдаж байгаа байгууллага:

1. Үндэсний номын сан;

2. Улсын эрдэнэсийн сан;

3. Шинжлэх ухааны академийн Палеонтологийн төв;

4. Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн.

### 5.4. Шашны байгууллага:

1. Бурхан шашинтны төв Гандантэгчинлан хийд.

## Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

6.1. хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохицуулах, төлөвлөлтөөр хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам гүйцэтгэнэ;

6.2. хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжил арга зүй, удирдамжаар хангах ажлыг Соёлын өвийн төв гүйцэтгэнэ;

6.3. хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцна;

6.4. хөтөлбөрийг Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан шат шатны бүртгэл-мэдээллийн сан хамтран хэрэгжүүлнэ.

## Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2006-2008 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

## Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Соёлын өвийн төв, соёлын өв хадгалагдаж байгаа байгууллагууд зөвшилцсөний үндсэн дээр жил жилээр төлөвлөн хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг дараахь хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ:

1. улсын болон орон нутгийн төсөв;
2. тусгай зориулалтын сан;
3. гадаад орон, олон улсын байгууллагын хөрөнгө, хандив;
4. өөрийн үйл ажиллагааны орлого.

## Ес. Хөтөлбөрийн төсөв

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал	Төсөв (сая.төг)	Хугацаа он	Санхүүжилт
1	Соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулах программ хангамж боловсруулах	15.000.000	2006	Тусгай зориулалтын сангаас
2	Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан болон соёлын өвийг хадгалж байгаа байгууллагыг гэрэл зургийн тоног төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд ашиглагдах компьютер, дагалдах хэрэгслээр хангах	57.900.00	2006	2006 оны БСШУ-ны салбарын төсвийн багцаас
		108.000.000	2006	Өөрийн үйл ажиллагааны орлогоос
3	Программ хангамж, техник хэрэгсэл дээр ажиллах боловсон хүчний зардал	5.600.000	2006	Тусгай зориулалтын сангаас
		32.400.000	2007-2008	Улсын төвлөрсөн төсвөөс
4	Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санд соёлын өвийг бүрэн хамруулахад зориулсан гарын авлага, заавар, удирдамж боловсруулах, хэвлэх, олшруулах зардал	1.200.000	2006	Тусгай зориулалтын сангаас
5	Үндэсний соёлын өвийн мэдээллийг Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд төвлөрүүлэн архивлан хадгалах	23.000.000	2007-2008	Улсын төсвөөс
6	Сүлжээний зардал (СӨТ)	1.260.000	2006	2006 оны Соёлын өвийн төвийн төсвөөс
	Бусад 35 байгууллага	14.700.000	2006	БСШУ-ны сайдын багцаас
		29.400.000	2007-2008	Улсын төсвөөс
<i>Нийт дүн</i>		288.460.000		

Соёлын өвийн мэдээллийн сүлжээний хөрөнгийг хөтөлбөр хэрэгжүүлэх 3 жилийн хугацаанд хөтөлбөрийн зардлаас гаргах ба хөтөлбөр дуусмагц тухайн аймгийн Засаг дарга, улсын музейн захирал, бусад байгууллагууд он оны төсөвтөө тусгаж үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл хөтөлбөрт хамрагдсан байгууллага 2008 оноос хойш жил бүр тухайн байгууллагынхаа төсвийн урсгал зардалд 420.000 төгрөгийг нэмж төлөвлөнө. Нийт 36 байгууллага улсын болон орон нутгийн төсвөөс 2009 оноос жил бүр 15.120.000 төгрөгийг зарцуулах юм.

### Арав. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

- соёлын өвийн талаархи мэдээлэл бүрэн тоон системд орно;

- соёлын өвийн мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болж, орчин үеийн мэдээллийн түвшинд хүрсэн байна;

- соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангийн тогтолцоо сайжирна. Электрон шуудангаар бүртгэл-мэдээллээ авдаг тогтолцоонд орно;

-соёлын өвийн мэдээллийг шуурхай харилцан солигцох нөхцөл бүрдэнэ. Соёлын өвийн талаархи бүртгэл-мэдээлэлд орсон өөрчлөлт болон холбогдох бусад мэдээллийг шууд сүлжээгээр авч байна;

-соёлын өвийн бүрэн мэдээлэлтэй болж ашиглах, сурталчлах таатай орчин бүрдэнэ. Соёлын өвийн мэдээллийн тодорхой хэсгийг тухайлбал, үл хөдлөх дурсгалын талаархи мэдээллийг интернетэд тавьж сурталчлах ба хөдлөх дурсгалын зарим мэдээллийг зөвхөн ажлын хэрэгцээнд кодоор ашигладаг болно;

-соёлын өвийн бүртгэл-мэдээллийг найдвартай архивлан хадгална. Архивын зориулалтын сейфэнд, архивын журмын дагуу хадгалах нөхцөлтэй болно.

## Арван нэг. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

11.1. Соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулах програм хангамжийн шаардлага хангасан байдал.

11.2. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал.

-гэрэл зургийн тоног төхөөрөмжийн тоо;

-мэдээллийн сүлжээнд ашиглагдах компьютер, дагалдах хэрэгслийн тоо.

### 11.3. Хүний нөөцийн асуудал:

-зохион байгуулсан сургалт-семинарын тоо;

-программ хангамж, техник хэрэгсэл дээр ажиллах талаар дадлагажсан хүний тоо.

11.4. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өвийн тоо (байгууллагаар);

а/улсын болон шашны байгууллагад хадгалагдаж байгаа түүх, соёлын хөдлөх дурсгалын тоо;

б/үл хөдлөх дурсгалын тоо;

в/утга соёлын өвийн тоо.

11.5. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд соёлын өвийг архивлан хадгалсан байдал.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

### "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-ийг шагнах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Болзлын шаардлага хангаж, өндөр амжилт гаргасан Архангай аймгийн Ихтамир сумын Хөхнуур багийн малчин Цэдэндоогийн Доржсүрэн, Архангай аймгийн Батцэнгэл сумын Баян-Уул багийн малчин Сүрэнгийн Алтантогтох, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын 6 дугаар багийн малчин Бисинбайн Сайболат, Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын 1 дүгээр багийн малчин Товуугийн Намхай, Булган аймгийн Орхон сумын 3 дугаар багийн малчин Жамсрангийн Чулуун, Булган аймгийн Баян-Агт сумын Шарга багийн малчин Шагдарын Дамбийжанцан, Говь-Алтай аймгийн Бугат сумын 1 дүгээр багийн малчин Мангалжавын Бямбаа, Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Баянхонгор багийн малчин Мягмарын Чагнаадорж, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 5 дугаар багийн малчин Галсангийн Майнбаяр, Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар багийн малчин Түнтүүгийн

Дарьсүрэн, Дорнод аймгийн Сэргэлэн сумын 2 дугаар багийн малчин Чавдагийн Повдорж, Дорноговь аймгийн Алтанширээ сумын Зараа багийн малчин Дамдингийн Цэдэвдорж, Дундговь аймгийн Баянжаргалан сумын 2 дугаар багийн малчин Дондогдоржийн Болдбат, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2 дугаар багийн малчин Дамбажамцын Дуламсүрэн, Завхан аймгийн Сонгюю сумын Айрагнуур багийн малчин Гочоогийн Намхайнямбуу, Өвөрхангай аймгийн Хужирт сумын 3 дугаар багийн малчин Доржийн Цэрэнчимэд, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст багийн малчин Ренчиндооровын Баатар, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 8 дугаар багийн малчин Гочоогийн Батнасан, Сүхбаатар аймгийн Асгат сумын Их-Уул багийн малчин Дугарын Баяраа, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 1 дүгээр багийн малчин Төмөрийн Мөнхбат, Төв аймгийн Баянжаргалан сумын 1 дүгээр багийн малчин Дариймаагийн Батбаатар, Төв аймгийн Өндөрширээт сумын 3 дугаар багийн малчин Гомбо-

Очирын Энхтөр, Увс аймгийн Сагил сумын Үүрэгнуур багийн малчин Батаагийн Доржсүрэн, Увс аймгийн Цагаанхайрхан сумын Хулж багийн малчин Дамдинсүрэнгийн Мөнхжаргал, Ховд аймгийн Чандмань сумын Тахилт багийн малчин Рэнцэндаваагийн Цэндсүрэн, Ховд аймгийн Манхан сумын Зэрэг гол багийн малчин Хандаагийн Эрдэнээ, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын 4 дүгээр багийн малчин Ёндонгийн Магсар, Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Баянцогт багийн малчин Гомбоцэрэнгийн Сампил, Хэнтий аймгийн Баянхутаг сумын 3 дугаар багийн малчин Лувсансүрэнгийн Лувсанбаяр, Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Шархоолой багийн малчин Даваагийн Баттогтох нарыг "Улсын сайн малчин"-аар.

2. Архангай аймгийн Түвшрүүлэх сумын "Багахангай" ХХК, Булган аймгийн Орхон сумын "Орхонмандал" ХХК, Төв аймгийн Жаргалант сумын "Дэлгэр-Уянга" ХХК, Хөвсгөл аймгийн Тариалан сумын "Хөвсгөл Алтандуулга" ХК, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын "Мөнх-Онон" ХХК-ийг "Улсын тэргүүний тариаланч" хамт олноор;

3. Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 4 дүгээр багийн иргэн Жамекегийн Бахыт, Булган аймгийн Орхон сумын 5 дугаар багийн иргэн Юулайгийн Баасанжаргал, Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин багийн иргэн Дүгэржавын

Энэбиш, Дархан-Уул аймгийн Орхон сумын Баян-Өлзийт багийн иргэн Очирын Бадарч, Завхан аймгийн Улиастай сумын Жаргалант багийн иргэн Рүүрагчийн Омоонцоо, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 5 дугаар багийн иргэн Санжийн Гомбо, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр багийн иргэн Дансрангийн Баттөр, Увс аймгийн Улаангом сумын 1 дүгээр багийн иргэн Бандийн Хөхөө, Увс аймгийн Тариалан сумын Хөхөө багийн иргэн Баастын Найдан, Ховд аймгийн Буянт сумын Норжинхайрхан багийн иргэн Дадьбазарын Сайнохой нарыг "Улсын тэргүүний тариаланч"-аар тус тус шалгаруулсугай.

4. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-д олгох тэмдэг, үнэмлэх, дурсгалын зүйлд зориулж 25.0 (хорин таван) сая төгрөгийг өөрийн төсвийн багцаас гарган санхүүжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын үүрэг гүйцэтгэгч Д.Тэрбишдагвад зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ** **Д.ТЭРБИШДАГВА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 2 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

**Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 28.6-г үндэслэн Улсын Их Хурлын 2006 оны 25 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр хавсралт, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сөнгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар хавсралт, төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар хавсралт, төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталж

2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2005 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 110 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** **М.ЭНХБОЛД**  
**САНГИЙН САЙД** **Н.БАЯРТСАЙХАН**  
**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД** **Л.ОДОНЧИМЭД**

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард тэгрээр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл												
	T3-1	T3-2	T3-3	T3-4	T3-5	T3-6	T3-7	T3-8	T3-9	T3-10	T3-11	T3-12	T3-13
1	63440	67860	73710	78130	82550	88010	91910	96980	102310	107640	113360	118170	123630
2	67860	73320	79820	84890	89830	95030	99320	104130	110110	114790	126750	131430	134550
3	72410	78650	85930	91650	96980	102310	106600	111150	117910	121810	140400	142740	145470
4	76960	84110	92040	98280	104260	109460	113880	118040	125580	128830	-	-	-
5	81640	89570	98280	104780	111540	116350	121030	125060	132990	137280	-	-	-

УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАСГИЙН ГАЗАР, УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ҮНДСЭН ХУЛИЙН ЦЭЦ, ХУНИЙ ЭРХИЙН ҮНДСЭЙН КОМИСС, ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ, ҮНДСЭЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ, СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО БОЛОН ТЭГДСЭРТЭЙ АДИЛГАХ ТӨРИЙН БАЙГУУЛАГЫН АЖЛЫН АЛБАНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл										
	AA-11	AA-10	AA-9	AA-8	AA-7	AA-6	AA-5	AA-4	AA-3	AA-2	AA-1
1	78390	82550	88010	91780	96980	102310	107510	111540	118040	123110	129090
2	85410	89830	95030	99830	104130	109720	114270	118040	128960	134290	140010
3	92300	96980	102310	106340	111020	117000	121030	124800	140530	145470	150930
4	98930	104260	109590	113620	117910	124410	128050	131560	-	-	-
5	105950	111540	116350	120900	125060	131820	134810	138060	-	-	-

## ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард тэгрээр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл																	
	ТТ-1	ТТ-2	ТТ-3	ТТ-4	ТТ-5	ТТ-6	ТТ-7	ТТ-8	ТТ-9	ТТ-10	ТТ-11	ТТ-12	ТТ-13	ТТ-14	ТТ-15	ТТ-16	ТТ-17	ТТ-18
1	58890	63440	67860	72390	74360	75400	79950	82550	86140	88790	90220	91780	96980	102310	105820	111410	117390	123630
2	63570	67860	73320	78520	80600	82290	86970	89830	94900	95810	97500	99060	104130	110110	113360	125060	130260	134550
3	68250	72410	78650	84630	86970	89310	93990	96980	101660	102830	104650	106340	111150	117910	120770	139100	143130	145470
4	72800	76830	84110	90740	93340	96200	100860	104260	108290	109850	111800	113750	118170	125580	128180	-	-	-
5	78000	81640	89570	98720	99840	102960	107900	111540	114920	116870	118950	120900	125060	133380	135590	-	-	-

## ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

(сард тэгрээр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл													
	ТҮ-1	ТҮ-2	ТҮ-3	ТҮ-4	ТҮ-5	ТҮ-6	ТҮ-7	ТҮ-8	ТҮ-9	ТҮ-10	ТҮ-11	ТҮ-12	ТҮ-13	ТҮ-14
1	55900	56420	57850	59540	60710	65650	70590	75660	80470	86840	92950	101790	111670	121550
2	56420	57850	59540	60320	64740	70070	74880	79950	84890	91260	102310	110370	119080	131430
3	57850	59540	61490	63830	68770	74380	79430	84240	89180	95550	111670	118950	126490	141050
4	61490	63570	65260	67340	72800	78650	83330	88660	93600	99970	-	-	-	-
5	65520	67600	68770	70590	76830	83070	87100	92950	98020	104130	-	-	-	-



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 2 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Төрийн албаны тухай хуулийн 28.6-г үндэслэн Улсын Их Хурлын 2006 оны 25 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн жишгийг дор дурдсанаар шинэчлэн тогтоож 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дүүргийн Засаг дарга 123240-145340

Сумын Засаг дарга 114660-136370

Хорооны Засаг дарга 92820-110240

Багийн Засаг дарга 80600-97110

**Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай**

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим албан тушаалын цалингийн жишгийг тогтоох тухай" Засгийн газрын 2005 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 111 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**М.ЭНХБОЛД**

**САНГИЙН САЙД**

**Н.БАЯРТСАЙХАН**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**Л.ОДОНЧИМЭД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 2 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 7 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны болон иргэд хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн сард 53000 (тавин гурван мянган) төгрөг буюу нэг цагт 313 төгрөг 61 мөнгө байхаар шинэчлэн тогтоосугай.

**Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2005 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 112 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**М.ЭНХБОЛД**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**Л.ОДОНЧИМЭД**

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр

Дугаар 1/01

Улаанбаатар хот

**Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн зарим заалт үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.00 цаг

дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Янжинорлоо оролцов. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Орлог, Г.Занданшатар нар Цэцийн хуралдааныг итгэмжлэгдсэн төлөөлөгчгүй явуулж өгөх хүсэлтийг бичгээр гаргаж өгсөн болно.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 заалт Монгол Улсын үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн хэлэлцэж хянан шийдвэрлэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүдэд Н.Жанцан /илтгэгч/, Л.Рэнчин, П.Очирбат, Ж.Болдбаатар, Ж.Амарсанаа, Ч.Дашням, Д.Наранчимэг нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд өргөдөл гаргагч Нийслэлийн Баянгол дүүргийн 18

**Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 18 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Янжинхорлоо үндсэн хуулийн цэцэг хандаж 2005 оны 9 дүгээр сарын 27-нд гаргасан өргөдөлдөө:**

"Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27.2-т "Шүүх энэ хуулийн 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана", 27.1-д "Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад эзэлдүүлэгч болон Эрхийн улсын бүртгэлийн алба энэ хуульд заасан журмыг зөрчсөн бол эзэлдэгч нь шүүхэд гомдол гаргаж болох ба шүүх уг гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ" гэсэн нь зээлийн барьцаанд тавьсан үл хөдлөх эд хөрөнгийг эзэлдүүлэгч шууд өмчлөлдөө авах үндэслэл болсон гэрээний эрх зүйгээс үүдэлтэй маргааны талаар гомдол гаргах боломжгүй, зөвхөн эрхийн улсын бүртгэлийн алба бүртгэлийг шилжүүлэн хийх үйл ажиллагааны талаар л гомдол гаргах хязгаарлалттай болсон байна.

Ингэснээрээ үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэг үйл эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй" гэсэн заалттай харшиж байгаа юм.

Гэрээний талууд анх гэрээ байгуулахдаа хүсэл зоригоо харилцан зөв ойлголцож, үйлдлийнхээ хууль зүйн үр дагаврыг бүрнээ ухамсарласан эсэх, ийнхүү ухамсарлах эрх зүйн чадамжтай байсан эсэх, гэрээний нэг тал өөрт ашигтай, нөгөө талдаа хэт шударга бус нөхцөл тулган хүлээлгэсэн эсэх, гэрээний стандарт нөхцөл нь хуульд нийцсэн эсэх, стандарт нөхцөл хүчин төгөлдөр болсон эсэхийг гагцхүү шүүхийн байгууллага хянаж тогтоох эрхтэй. Энэхүү хяналтыг дээрхи шинэ хуулиар хасах нь үндсэн хуульд нийцэхгүй.

Банк, банк бус санхүүгийн байгууллагуудын байгуулж буй зээлийн гэрээнүүд гэрээний нэг тал санал болгодог, стандарт нөхцөл агуулдаг бөгөөд тэдгээрт зээлийн байгууллагууд өөрсдийн эрх ашгийн үүднээс барьцааны хөрөнгийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах тухай заалт оруулж өгөх нь дамжиггүй. Хууль хэрэгжиж эхэлсэн 2005 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн гэрээг ийнхүү байгуулж эхэлсэн. Гэтэл гэрээнд тавих шүүхийн хяналтыг хассанаар юуны өмнө эзэлдэгч иргэдийн эрх ашиг хохироход хүрч байна.

Арилжааны банкууд томоохон хуулийн этгээдүүдтэй хийх хэлцэлд ийм заалт оруулж, улмаар шүүхийн хяналтаас гаргах боломжтой. Учир нь гэрээний талууд аль аль нь зах зээл дээр мэргэжлийн шинжтэйгээр аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө хуулийн этгээдүүд, бизнесийн үйлдлийнхээ учир холбогдол, эрх зүйн үр дагаврыг сайтар мэдэж байх ёстой гэж тэднээс шаарддаг бололцоотой, нөгөө талаас мэргэжлийн хуульчдыг ч ажиллуулдаг.

Харин хувиараа эрхлэх гэр бүлийн аж ахуй, тэр тусмаа иргэн хүний хувьд ийнхүү шүүхийн хяналтаас гаргахыг эрх зүйт төрд хүлээн зөвшөөрдөггүй.

Иргэний хууль нь эрх зүйн этгээдүүдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулах гол хууль бөгөөд иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдасгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэдэг.

Тухайлбал, уг хуулийн 189 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил үйлчилгээ, эрхлэх талаар тухайн зах зээлд давамгайлж байгаа этгээд энэхүү үйл ажиллагааныхаа хүрээнд түүнд хандсан этгээдтэй гэрээ байгуулах үүрэгтэй бөгөөд нөгөө талдаа тэгш бус нөхцөл тулган санал тавих буюу гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй" гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллагуудыг санхүү, зээлийн үйлчилгээгээр зах зээлд давамгайлж буй этгээдүүд гэж үзэх бүрэн үндэстэй бөгөөд тэдгээрийн зүгээс иргэдэд ийнхүү тэгш бус нөхцөл тулгаж болохыг тусгай хууль гарган хүлээн зөвшөөрч болохгүй.

Өнөөгийн нөхцөлд шүүхийн журмаар зээлийн барьцааны хөрөнгийг банкууд худалдан борлуулж, учирсан хохирлоо гаргуулахын тулд тодорхой хугацаа шаарддаг ч шүүх гэрээг бүхэлд нь хянасны эцэст ихэнх тохиолдолд хохирлыг нь гаргуулан шийдвэрлэж байгаа билээ.

Банк, банк бус санхүүгийн байгууллагаас иргэдтэй байгуулсан гэрээ шүүхийн хяналтаас гадуур үлдэж, банк, банк бус санхүүгийн байгууллагууд давуу эрх эдлэх нь эрх зүйт төрийн үндсэн зарчим болох тэгш байх зарчмыг гажуудуулах төдийгүй иргэдийн дийлэнх нь газар хувьчилж аваагүй, харин орон сууцны 98 хүртэл хувь нь хувьчлагдсан өнөөгийн нөхцөлд иргэдийн зүгээс зээлийн барьцаанд тавьдаг гол зүйл нь орон

сууц бөгөөд амьжиргааны наад захын зайлшгүй эх сурвалж болсон орон байраа барьцаанд тавих гэрээ байгуулсан үйл ажиллагааг шүүх хянахгүй байх нь үндсэн хуульд хэрхэн нийцсэн эсэхийг шийдвэрлэж өгнө үү..." гэжээ.

**Хоёр. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Г.Занданшатар нар үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тэйлбэртаа:**

Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр үүсэх бөгөөд гэрээний аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан журмын дагуу барьцаанд тавьсан үл хөдлөх хөрөнгийг шүүхийн оролцоогүйгээр худалдан борлуулахтай холбогдсон асуудлыг зохицуулсан процессийн шинжтэй хууль юм.

Хэрэв талуудын хооронд аливаа хэлбэрээр гэрээ, хэлцэл байгуулаагүй, тухайн гэрээ хэлцлийг хуульд заасан журмын дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй, энэ талаар ямарваа нэгэн нотолгоо, баримт байхгүй бол ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаа үүсэхгүй.

Дээр дурдсанчлан ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах харилцаа нь талуудын сайн дурын үндсэн дээр байгуулсан гэрээнд үндэслэн үүсэх бөгөөд энэ харилцаа үүсэхэд төр аливаа хэлбэрээр оролцохгүй. Өөрөөр хэлбэл, энэ харилцаа нь иргэний эрх зүйн субъектуудын хооронд үүсч буй гэрээний эрх зүйн харилцаа юм.

Харин иргэн Д.Янжинхорлоогийн гаргасан өргөдөлд дурдсанчлан Үндсэн хуулиар олгосон хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн эсэх асуудал нь зөвхөн төр, иргэний хооронд үүсдэг онцлог харилцаанд тооцогддог байна. Түүнчлэн эзэл болон барьцааны гэрээ, гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдсон иргэний эрх зүйн харилцааны үед "эзэлдэгч" ба "эзэлдүүлэгч" хэмээх этгээдүүдийн "субъектив эрх" -ийн асуудал яригдах ба энэ нь үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө буюу "объектив эрх" -ээс тусдаа, өөр ойлголт юм. Энэ ч утгаараа Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуультай холбогдсон асуудал нь гэрээний эрх зүйн асуудал гэж үзэж байна.

Позитив буюу үүсмэл эрхийн хувьд хуулиар тогтоосон зохих хязгаартай байх бөгөөд бусад хүний эдлэх эрх, эрх чөлөөтэй харилцан

холбоотой, түүгээр нөхцөлдсөн байдаг. Түүнчлэн хүн позитив эрхээ хэрэгжүүлэхээс тодорхой нөхцөлд өөрийн үзэмжээр татгалзаж болдог ба үүнийгээ өөрийн үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрхийлдэг. Харин ийнхүү татгалзахад нь төрөөс аливаа хэлбэрээр нөлөөлөх ёсгүй байдаг юм байна.

Шүүхэд хандах эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах нь нэгдүгээрт, шүүхэд гомдол гаргахгүй байх идэвхтэй хэлбэрээр; хоёрдугаарт, гэрээтэй холбогдсон асуудлын хувьд маргааныг шүүхийн бус журмаар /шүүхийн оролцоогүйгээр/, эсхүл үл маргах журмаар шийдвэрлэхээр харилцан тохиролцсон үйлдэл буюу идэвхтэй хэлбэрээр илэрч болно. Үүний нэг жишээ нь арбитраар маргаанаа шийдвэрлүүлэх замаар шүүхэд гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах явдал гэж үзэж болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", мөн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "бүх шатны болон дагнансан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно" гэж тус тус заасан.

Иймээс арбитраар маргааныг хянан шийдвэрлэж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй" байхаар заасныг зөрчсөн гэж үзэх үү гэсэн асуудал үүсэх нь зайлшгүй. Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлд заасны дагуу "талууд гэрээндээ үл маргах журмаар биелүүлэхээр тохиролцож нотариатаар гэрчлүүлсэн тохиолдолд" холбогдох журмын дагуу шүүх шийдвэрийг баталгаажуулан шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулдаг. Энэ нь талууд гэрээгээр харилцан тохиролцсон "шүүхэд гомдол гаргах эрх" -ээ хэрэгжүүлэхээс сайн дурын үндсэн дээр татгалзах боломжийг хуульчилсан заалт юм.

Талууд үүргийн гүйцэтгэлийг хангуулахдаа шүүхийн бус журмаар асуудлыг шийдвэрлэхээр анх гэрээ байгуулахдаа зөвшөөрч, харилцан тохиролцсон тохиолдолд ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаа үүснэ. Нэгэнт гэрээг талууд сайн дурын үндсэн дээр байгуулсан, ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахыг зөвшөөрч харилцан тохиролцсон бол уг ажиллагааны үед "шүүхэд хандах эрх" -ийг зөрчсөн эсэх асуудал яригдахгүй.

Дээр дурдсан нөхцөл нь зөвхөн ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан тодорхой үе шатанд

хамаарах тул гэрээний аль нэг тал нь уг ажиллагаа үүсэхээс өмнө шүүхэд аливаа асуудлаар хандах эрхтэй. Харин ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар тохиролцсон ч зээлдүүлэгч, эрхийн улсын бүртгэлийн алба ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах хуульд заасан журмыг зөрчсөн бол зээлдэгч тухайн асуудлаар шүүхэд хандах эрхтэй бөгөөд энэ нь тус хуулийн 27.1 дэх хэсгээр баталгаажсан болно.

Мөн хуулийн 27.2 дахь хэсгийн заалт нь зөвхөн зээлдэгчид хамаарах тул зээлдэгч эрхийн чадамжгүй байсан, эсхүл хуульд заасан журмын дагуу зохих зөвшөөрөл аваагүй зэрэг үндэслэлээр өөрийн зөрчигдсөн эрх, эрх чөлөөгөө хамгаалуулахаар гуравдагч этгээд шүүхэд хандах эрх нь нээлттэй байна.

Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль гэрээний талуудад үүргийн гүйцэтгэлийг түргэн шуурхай, зардал багатайгаар худалдан борлуулах сонголт бүхий боломжийг бүрдүүлж байгаа. Нэгэнт гэрээний талуудад үүргийн гүйцэтгэлийг шүүхийн бус журмаар хангуулах нь ашигтай хэмээн үзэж байхад төрөө тухайн асуудалд оролцон талуудад ашигтай бус хувилбарыг тулгах нь гэрээний эрх чөлөөнд ноцтойгоор халдаж буй хэрэг юм. Энэ нь гэрээний талуудын эрх ашгийг хөндөөд зогсохгүй, улс орны эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэн, зах зээлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад хүргэдэг юм байна.

Гэрээний эрх чөлөө нь эрх зүйн утгаараа талуудад өөрсдөө сайн дураараа, хүсэл зоригоо илэрхийлэн хууль зүйн тодорхой үр дагавар бий болгох эрх чөлөөг олгож, гэрээгээр эдлэх эрх, хүлээх үүргээ иргэний эрх зүйн зохицуулалтын диспозитив аргаар тодорхойлох боломжийг хангахад чиглэсэн байдаг бол эдийн засгийн утгаараа талуудын хооронд баялгыг бүтээхэд чиглэсэн төрөл бүрийн харилцааг чөлөөтэй үүсгэх үндсэн суурь болж өгдөгөөрөө чухал ач холбогдолтой ухагдахуун юм.

Ийм ч учраас эдийн засгийг хөдөлгөгч үндсэн хөдөлгүүр болсон гэрээний эрх чөлөөний зарчмыг тууштай баримтлах нь зөв болов уу ... гэжээ.

**Гурав.Өргөдөл гаргагч иргэн Д.Янжинхорлоо Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн тэйнбэртэй холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд 2005 оны 11 дүгээр сарын 15-нд ирүүлсэн нэмэлт тэйнбэртээ:**

Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Хүн бүр хууль,

шүүхийн өмнө тэгш эрхтэй" гэсэн заалтыг чухамхүү Улсын Их Хурлын баталсан дээрхи хуулийн 27.1, 27.2 дахь хэсгийн заалтаар, тодруулбал "шүүх энэ хуулийн 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана" гэж заасан нь хуулиараа зөрчиж байгаа юм.

Арбитрын гаргаж буй шийдвэр чанарын хувьд шүүхийнхтэй адил байх ёстой, энэ ч шаардлагад арбитрын байгууллага нийцүүлэн ажилладаг. Гэрээний талууд тэгш эрхтэйгээр гэрээ байгуулах процесс оролцсон, өөрөөр хэлбэл эрхийн хувьд тэгш байдалтай байж чадсан тохиолдолд талууд маргаанаа шүүхээр бус арбитраар шийдүүлэхээр харилцан тохиролцож бүрэн бололцоотой. Талуудын энэ хүсэл зоригийг хүндэтгэх үүднээс шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг билээ. Харин нэг талд нь давамгайл байдалтай банк, банк бус санхүүгийн байгууллага, нөгөө талд нь жирийн хэрэглэгч буюу иргэн хүн гэрээ байгуулж буй банкны зээлийн харилцаанд банкны боловсруулсан зээлийн гэрээнд иргэн хүн өөрчлөх бололцоогүйгээр, зөвхөн гарын үсгээ зурах л үлддэг. Энэ гэрээнд банк өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс барьцааны үл хөдлөх хөрөнгийг худалдах шүүхийн бус аргыг сонгох нь дамжиггүй, ингэж ч байгаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн алба нь Засгийн Газрын нэг л агентлаг болохоос өмчлөх эрхийг зээлийн барьцааны гэрээг Үндэслэн дуусгавар болгодог, өмчлөх эрхэд халддаг байгууллага биш. Эндээс барьцааны гэрээг л бүртгэх ёстой. Зөв буруу, эрх нь зөрчигдсөн этгээдийн эрхийг сэргээх үндэслэл, талууд эрх, үүргээ эхрэн биелүүлсэн, эрх сэргээх арга зоргийг тогтоох эрхийг Үндсэн хуулиар гагцхүү шүүхийн байгууллагад олгосон байдаг. Иймд иргэн хүний ийнхүү шүүхээр эрхээ сэргээлгэх эрхийг Улсын Их Хурал хууль гаргаж хаах ёсгүй гэжээ.

**Дөрөв. Үндсэн хуулийн цэц энэхүү марагданы 2005 оны 11 дүгээр сарын 16-ны одор дунд суудлын хуралдаанаар хянан хэлэлцэж 2/08 дугаар дүгнэлт гаргасан бөгөөд уг дүгнэлтэд,**

"...Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27.2-т "Шүүх энэ хуулийн 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана" гэсэн заалтыг зээлдэгчийн шүүхэд хандах, шударга шүүхээр шүүлгэх тухай үндсэн хуулиар олгогдсон эрхийг хууль гарган хязгаарласан байна гэсэн үндэслэлээр үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "Монгол улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ

хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх, ...эрхтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна..." гэжээ.

**Төв. Үндсэн хуулийн цэцийн дэргэц дүгнэлтийг Улсын Их Хурал 2005 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж** "Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27.2-т "Шүүх энэ хуулийн 27.1-т зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх, ...эрхтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 2/08 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй" гэсэн 75 дугаар тогтоол гаргажээ.

## ҮНДЭСЛЭЛ:

1. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27.2-т "Шүүх энэ хуулийн 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана" гэж заасан нь эзэлдэгчийн шүүхэд хандах, шударга шүүхээр шүүлгэх тухай үндсэн хуулиар олгогдсон эрхийг нь шууд хязгаарласан гэх үндэслэлтэй байна.

2. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27.1-д "Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад эзэлдүүлэгч болон Эрхийн улсын бүртгэлийн алба энэ хуульд заасан журмыг зөрчсөн бол шүүхэд гомдол гаргаж болох"-оор хуульчилсан атлаа уг хуулийн 27.2-т эзэлдэгчийн шүүхэд гомдол гаргах эрхийг зөвхөн дээрх үндэслэлээр хязгаарлаж байгаа нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "Монгол улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх, ...эрхтэй" гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

3. Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 2/08 дугаар дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрөөгүй тухай

үндэслэлээ Улсын Их Хурлын 2005 оны 75 дугаар тогтоолд заагаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27.2-т "Шүүх энэ хуулийн 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх, ...эрхтэй" гэсэн заалтыг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 2/08 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн тухай Улсын Их Хурлын 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 75 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гармалцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГА	Ж.БЯМБАДОРЖ
ГИШҮҮД	Н.ЖАНЦАН
	Л.РЭНЧИН
	П.ОЧИРБАТ
	Ж.БОЛДБААТАР
	Ж.АМАРСАНАА
	Ч.ДАШНЯМ
	Д.НАРАНЧИМЭГ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 265958  
Индекс 14003

☎ 320487  
Хэвлэлийн хуудас 3.5

